


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн
81 дүгээр тогтоолын хавсралт



"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь (цаашид "Дүрэм" гэх) "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны зарчим, чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид "компани" гэх) нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байна.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

1.5. Компани нь "Эрчист Монгол" ТӨХХК-ийн өхин компани бөгөөд нэгдлийн зарчмаар менежментийн гэрээ байгуулан ажиллаж, менежментийн төлбөрийн хувь хэмжээг компанийн бөрлуулалтын өрлогын 1 (нэг) хувь хүртэл байхаар тогтооно.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор хассан/

1.6. Компани нь "Эрчист Монгол" ТӨХХК-ийн хууль, тогтоомжийн хүрээнд баталсан дүрэм, журам, стратеги төлөвлөгөө, зөвлөмж, бодлогын баримт бичиг ээргийг мөрдөж ажиллана.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор хассан/

ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, БАЙРШИЛ

2.1. Компанийн оноосон нэр нь монгол хэлээр "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, товчилсон нэр нь "МХС" ХХК, англи хэлээр "Information Communications Network" LLC, товчилсон нэр "ICN" LLC болно.

2.2. Компанийн байршил нь түүний ерөнхий захиргаа оршин байгаа газраар буюу улсын бүртгэлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлогдоно.

Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг I хороо, Энхтайваны өргөн чөлөө-1, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн төв байр.

2.3. Хаягийн өөрчлөлтийг компанийн Гүйцэтгэх удирдлага тухай бүр Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ГУРАВ. КОМПАНИЙН БЭЛГЭДЭЛ, ТАМГА, ТЭМДЭГ

3.1. Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Компанийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

3.3. Компанийн тамга, тэмдгийг компанийн Гүйцэтгэх удирдлага, эсхүл түүнээс итгэмжлэн хариуцуулсан этгээд түшнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

4.1. Компани ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэнэ.

4.2. Компанийн үйл ажиллагаа нь ил тод, бие даасан байна.

4.3. Компани хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын талаар аливаа шийдвэр гаргахдаа тухайн хөрөнгө оруулалтын эдийн засаг, санхүүгийн үр өгөөж, тооцоо, судалгаанд суурилсан байна.

ТАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

5.1. Компанийн үндсэн зорилт нь Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, Хувьцаа эзэмшигчийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, ашгийн төлөө ажиллаж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэхэд оршино.

5.2. Компани нь дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ:

5.2.1. Хот, хот хоорондын харилцаа холбооны дамжуулах суваг, сүлжээний түрээсийн үйлчилгээ;

5.2.2. Интернетийн бөөний болон олон улсын интернетийн дамжуулах үйлчилгээ;

5.2.3. Харилцаа холбооны хэрэглэгчийн шугамын үйлчилгээ;

- 5.2.4.Тоног төхөөрөмжийн байр, цамхаг, байр талбайн түрээсийн үйлчилгээ;
 - 5.2.5.Харилцаа холбооны худаг сувагчлалын түрээсийн үйлчилгээ;
 - 5.2.6.Техник менежментийн үйлчилгээ;
 - 5.2.7.Мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйл ажиллагаа;
 - 5.2.8.Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаа;
 - 5.2.9.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ;
 - 5.2.10.Радио давтамж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийх, лабораторийн үйл ажиллагаа;
 - 5.2.11.Бусад сургалтын үйл ажиллагаа;
- 5.3. Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагааг эрхэлж болно. Энэ тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 5.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ.
- 5.5. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

ЗУРГАА. КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, НОГДОЛ АШИГ, САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

- 6.1. Компанийн хөрөнгө нь 100 (нэг зуу) хувь төрийн өмчид байх бөгөөд 1 (нэг) хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээд байна. Компанийн хувьцаа нь хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр гарах хүртэл нийтэд арилжаалагдахгүй.
- 6.2. Компанийн хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ нь нийт хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
- 6.3. Ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.4. Компани нь “Ахмадын сан”-тай байх бөгөөд тус сангийн жилд хуваарилах мөнгөн хөрөнгийн хэмжээг тухайн оны бизнес төлөвлөгөөнд тусгаж батлуулна.
- 6.5. Компани нь салбар, төлөөлөгчийн газар, охин компанитай байж болно:
- 6.5.1.Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна;
 - 6.5.2.Салбар, төлөөлөгчийн газар нь түүнийг байгуулсан компаниас баталсан орлогын төлөвлөгөөний дагуу орлого төвлөрүүлэх үүргийг хүлээнэ;
 - 6.5.3.Салбар, төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа компанийн нэрийн өмнөөс явуулна;
 - 6.5.4.Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хэвлэмэл хуудас, тэмдэгийг гүйцэтгэх удирдлагаас баталсан журмын хүрээнд ашиглана;

6.5.5.Охин компанитай холбогдох харилцааг Иргэний хууль болон Компанийн тухай хуулиар зохицуулна.

ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

7.1.Компанийн удирдлага нь дараахь бүтэцтэй байна:

7.1.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал;

7.1.2.Төлөөлөн удирдах зөвлөл;

7.1.3.Гүйцэтгэх удирдлага.

НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

8.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Засгийн газраас эрх олгосон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

8.2. Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын (ТӨБЗГ) хурал нь байгууллагын дээд шатны хурал байна.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

8.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

8.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрвөн) сарын дотор хуралдуулна.

8.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

8.5.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

8.5.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг томилохдоо зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс дэмжигдсэн этгээдүүдийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэнэ. Нэр дэвшигч шаардлага хангахгүй гэж үзсэн тохиолдолд дахин нэр дэвшүүлэх тухай шийдвэр гаргах;

8.5.3.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;

8.5.4.Компанийн Гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгөх;

8.5.5.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.5.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн жилийн ажлын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

8.5.7.Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон хугацааг тодорхойлох;



8.5.8.Компанийн тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудал.

8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд хэлэлцсэн асуудал, хурлын явцын талаар тэмдэглэл хөтөлнө.

ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

9.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (есөн) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 (гурав) нь хараат бус гишүүн байна.

9.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх асуудлыг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2 дахь хэсэг болон бусад холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлагыг хангасан байна.

9.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3, 9.4 дэх хэсэгт заасан нэмэлт үүргийг хүлээнэ.

9.6. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.6.1.Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тогтоох;

9.6.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үндэслэн компанийн бизнес төлөвлөгөөг батлах;

9.6.3.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

9.6.4.Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах;

9.6.5.Компанийн Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг түдгэлзүүлэх;

9.6.6.Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшууллын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

9.6.7.Компанийн тайлан, тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэх;

9.6.8. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн бодит үнийг тогтоох;

9.6.9.Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

9.6.10.Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах,

9.6.11.Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.6.12.Компанийг өөрчлөн байгуулах талаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.6.13.Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

9.6.14.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

9.6.15.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан асуудлыг шийдвэрлэх.

9.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцоноор хүчин төгөлдөр болно.

9.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.

9.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

9.10. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, тэмдэглэлд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

9.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

9.13. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

9.14. Хороодын гишүүд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний 2/3 хараат бус гишүүн байна.

9.15. Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.

9.16. Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

9.16.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

9.16.2. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;

9.16.3. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

9.16.4. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

9.16.5. Компанийн тухай хууль, энэхүү дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

9.17. Нэр дэвшүүлэх хороо нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

9.17.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

9.17.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

9.17.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

9.17.4. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

9.17.5. Компанийн тухай хууль, энэхүү дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

9.18. Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

9.18.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

9.18.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

9.18.3. Компанийн мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

9.18.4. Компанийн тухай хууль, энэхүү дүрэмд заасан болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

9.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг Компанийн тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

9.20. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82.2-т заасан үүргийг хүлээх бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

9.21. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

9.22. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлыг шийдвэрлүүлэхээр энэхүү дүрмийн 8.1-т заасан этгээдэд хэдийд ч хандаж болно.

9.23. Энэ дүрмээр болон хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхээр тогтоогоогүй Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн Гүйцэтгэх захирал байна.

10.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөл сонгож, өөрчилж, түүний бүрэн эрхийг тогтооно.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

10.3. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

10.4. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

10.5. Гүйцэтгэх захирал нь компанийн ерөнхий нягтлан бодогч, ерөнхий инженерийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

10.6. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

10.6.1. төрийн алба, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалд 10 (арав)-аас доошгүй жил ажилласан, харилцаа холбооны салбарт 15 (арван тав)-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, мэдээллийн технологи, харилцаа холбоо, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр, магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, менежментийн ур чадвартай;

10.6.2. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хугацаа хэтэрсэн зээл болон батлан даалтын гэрээгээр хүлээсэн өргүй байх;

10.6.3. авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэлгүй байх;

10.6.4. ёс зүй болон хувь хүний нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

10.7. Гүйцэтгэх захирлын дэргэд өдөр тутмын болон шуурхай ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

10.8. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

- 10.8.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;
- 10.8.2.Компанийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;
- 10.8.3.Компанийн тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах;
- 10.8.4.Компанийн бизнес төлөвлөгөөг батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах;
- 10.8.5.Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, стандарт, норм, норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 10.8.6.Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 10.8.7.Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;
- 10.8.8.Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;
- 10.8.9.Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, салбар, төлөөлөгчийн газрын дарга, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх, шагнаж урамшуулах, сахилгын болон бусад хариуцлага ногдуулах;
- 10.8.10.Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;
- 10.8.11.Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах, биелэлтийг хангуулах;
- 10.8.12.Компанийн хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;
- 10.8.13.Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

11.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, Ерөнхий инженер, Ерөнхий нягтлан бодогч, хэлтсийн дарга газрын захирал түүнээс дээш албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

11.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

12.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:

12.1.1. өмчлөгчийн хяналт;

12.1.2. дотоод хяналт;

12.1.3. хөндлөнгийн аудит.

12.2. Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

12.3. Аудитын хороо нь компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

12.4. Аудитын хороо нь үйл ажиллагаа явуулахдаа энэхүү дүрмээр олгогдсон эрхийг эдэлнэ.

12.5. Компанийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлнэ. Дотоод хяналтын журмыг компанийн гүйцэтгэх удирдлага батална.

12.6. Дотоод хяналт шалгалтын нэгж нь компанийн үйл ажиллагаа, ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллага болон компанийн Гүйцэтгэх захирлын гаргасан тушаал, шийдвэрт нийцэж байгаа эсэхэд компанийн хэмжээнд хяналт тавьж, гүйцэтгэл, санхүү, техник технологийн чиглэлээр дотоод хяналт шалгалт хийж ажиллана.

12.7. Дотоод хяналт шалгалтын нэгж нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн тайлан, акт, дүгнэлт, албан даалгавар, зөвлөмжийг шууд Гүйцэтгэх захиралд тайлагнана.

12.8. Компанийн хөндлөнгийн аудитыг эрх бүхий байгууллагаас сонгосон мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэнэ.

12.9. Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

АРВАН ГУРАВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

13.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуульд заасны дагуу хийнэ.

13.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийнэ.

13.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэ дүрмийн 13.1, 13.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

14.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

14.2. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

14.3. Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

14.4. Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусна.

АРВАН ТАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

15.1. Компани Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтөлж хагас жил, жилийн санхүүгийн тайлан гаргана.

15.2. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно.

15.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙН БАРИМТ БИЧГИЙН ХАДГАЛАЛТ

16.1. Компани нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу баримт бичгийг хадгалах үүрэгтэй.

16.2. Компани нь баримт бичгийг удирдлагын байрлаж байгаа газар буюу улсын бүртгэлд бүртгүүлсэн газарт хадгална.

16.3. Компани нь өөрийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг өөрийн архивд хадгална. Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу баримт бичгийг хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа улсын архивд шилжүүлнэ.

16.4. Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээртэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

АРВАН ДОЛОО. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

17.1. Компанийг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгана.

17.2. Татан буулгах комисс томилогдсоноор компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, эрх нь татан буулгах комисст шилжинэ.


АРВАН НАЙМ. БУСАД

18.1. Энэ дүрэмд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

18.2. Энэ дүрэм болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

18.3. Энэ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн 18.2-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

/Энэ заалтыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоолоор өөрчилсөн/



---o0o---